



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/684

Ховд

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн IV.4.1.2. дахь заалтад тусгагдсан “Үүрэн телефоны сүлжээ дамжуулах станц”-ийн байгууламжийг Ховд аймгийн Дөргөн суманд “Эйч ти эл” ХХК-ний барьж гүйцэтгэсэн ажлыг ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: З.Өмиртай – Аймгийн ерөнхий архитектор бөгөөд,
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Ш.Самданжамц - Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын мэргэжилтэн

Ч.Болор-Эрдэнэ - Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын мэргэжилтэн

Б.Бат-Оюун- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын харилцаа,
холбооны хяналтын улсын байцаагч

Б.Алтанхуяг-“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ний
ерөнхий инженер

С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга

Н.Уламбаяр - “Эйч ти эл” ХХК-ний захирал

Нарийн бичгийн

дарга

М.Баяржаргал- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын хот байгуулалтын кадастр, зураг төсөл
магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. “Үүрэн телефоны сүлжээ дамжуулах станц”-ийн байгууламжийг барилгын
ажлыг зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг
комиссын дарга /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



М.БЯЯРЖАРГАЛ